Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд Орхон аймаг дахь төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор Б.Азжаргал нар хариуцаж хэрэгжүүлэв.

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ний өдрийн 03/76 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Жаргалант сумын ЗДТГазар нь Төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар төрийн албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн чадварлаг захиргааны байгууллага болох нь бидний эрхэм зорилго дэвшүүлсэн байна.

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газар нь байгууллагын хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой хөгжлийг хангах, албан хаагчдын нийгмийн баталгаа сайжруулах зорилтын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлэн ажиллажээ. Үүнд:

- Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийг боловсронгуй болгон шинэчлэн баталж, мөрдүүлэх.
- Мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх
- Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.
  Үүнд:
- Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоол
- Төрийн алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай /ЗГ-ын 472 дугаар тогтоол/
- Төрийн албаны тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-аас гарсан тогтоол, шийдвэрүүд
- Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын тушаал, шийдвэрүүд
- Бусад хууль тогтоомж, дүрэм, журам

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1,499,336.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,993.4 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөөгүй бөгөөд нийт орлогын дүн жилийн дүн тул 2,801,813.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 28,018.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 508,363.4 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,805.1 | 1,405.1 | 1,400.0 |
| Авлага | 209,707.0 | 271,481.2 | 61,774.2 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 133,925.5 | 82,412.8 | 51,512.7 |
| Үндсэн хөрөнгө | 4,475,658.9 | 4,907,268.2 | 431,609.3 |
| **Нийт хөрөнгө** | **4,823,751.6** | **5,332,115.1** | **508,363.4** |
| Өр төлбөр | 36,222.2 | 103,692.0 | 67,469.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,787,529.4 | 5,228,423.1 | 440,893.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,823,751.6** | **5,332,115.1** | **508,363.4** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 2,805.1 мянган төгрөг болж 1,400.0 мянган төгрөгөөр буурсан нь ахмадын сангаас ахмадуудад олгосон байна.

Авлага дансны үлдэгдэл 209,706.9 мянган төгрөг нь 56,014.9 мянган төгрөгөөр өссөн нь Шилдэг сумын шагналын мөнгөний үлдэгдэл санхүүжилт болох 25,339.6 мянган төгрөг, уурын зуухны моторын санхүүжилт 4,500.0 мянган төгрөг, уурын зуухны нүүрсний 27,531.8 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 120,203.8 мянган төгрөг болж 13,721.7 мянган төгрөгөөр буурсан  нь аж ахуй, бараа материалын тооллого хийн ашиглагдахгүй бараа материалыг зарлагдсанаар үлдэгдэл буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,907,268.2 мянган төгрөг болж 431,609.3 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- ХААЯамнаас 143,282.8 мянган төгрөгийн тариалангийн талбайн хашаа, трактор төмсний иж бүрдэл тоног төхөөрөмж,
- Аймгийн хөрөнгө оруулалтаар 262,810.5 мянган төгрөгийн 505 тонн зоорийг орлогд авсан байна.
- Сумын ОНХСангийн хөрөнгө оруулалтаар 430,403.1 мянган төгрөгийн хөрөнгө орлогд хүлээн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 117,260.3 мянган төгрөг болж 81,038.2  мянган төгрөгөөр өссөн нь Жаргалант сумын уурын зуухны нүүрсний өр төлбөр 27,531.7 төгрөг, ндш-ийн өглөг

180.4 мянган төгрөг, уурын зуухны тоног төхөөрөмжийн 4,500.0 мянган төгрөг, тендерийн буцаан олголттой холбоотой 48,826.1 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,173,267.1 мянган төгрөгөөр боловсруулан төсвийн захирагчид хүргүүлсэн бөгөөд 2020 онд зарцуулах нийт зарлагыг 1,173,267.1 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,173,267.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,170,816.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 2,450.3 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,170,816.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 434,284.4 мянган төгрөг, нийт 1,605,101.05 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,483,847.3 мянган төгрөгийг зарцуулж 30,124.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээлэл оруулахаас хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 13 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд нөхөн байршуулж 2020 оны дотоод аудитын нэгдсэн дүгнэлтээр 93% биелэлттэй дүгнэгдсэн байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газарт 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 6 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн ба албан шаардлага болон зөвлөмж 86.2 хувийн хэрэгжилттэй байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | |
| Албан шаардлага | 6 | 93,218.5 | 1 | 93,218.5 | 0 | 0 | |
| Зөвлөмж | 3 | 39,027.3 | 2 | 2,805.1 | 1 | 36,222.2 | |
| **Нийт дүн** | **9** | **132,245.8** | **3** | **96,023.6** | **1** | **36,222.2** | **86.2** |

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 108,758.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс 72,053.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 150.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт 36,554.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа**

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 санхүүгийн тайланд 87,100.0 мянган төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд: Төлбөргүй хүлээн авсан орлогыг худалдан авсан худалдан зарцуулсан гэж бүртгэж Үр дүнгийн тайланд бараа материалын тайлангийн тээвэр шатахууны тайланд 9,400.0 мянган төгрөг, аж ахуй материалын тайланд 27,100.0 мянган төгрөгийн алдаа гарсан байна. 27,500.0 мянган төгрөгийн нүүрсний авлага, уурын зуухны моторын үнэ 4,500.0 мянган төгрөгийн авлага дутуу бүртгэсэн байна.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 72,203.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрсэнээс 72,053.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 150.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн /тухайн онд үүссэн 46,713.9 мянган төгрөгийн өглөг, 25,339.6 мянган төгрөгийн авлага барагдаагүй/ зөвлөмж хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Албан шаардлага өгөв.

2. Жаргалант багийн зохион байгуулагчид 150.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.4-д "төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлбөрийн акт тогтоов

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 03/258 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 36,554.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газарт хөрөнгийн тооллого хийх шаардлагатай гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

**Зардлын данстай холбоотой асуудал**

**1.1. Илрүүлэлт:**

Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй, жолоочийн тооцооны хуудас баталгаажаагүй, баримтаар 12,941.5 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дугаар тушаал "жишиг норм батлах тухай" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**1.2. Эрсдэл:**

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

**1.3. Өгсөн зөвлөмж:**

Автомашины шатахуун зарцуулалтын хэмжээг туршилт хийж баталгаажуулж, бодит зарцуулалтыг үнэн зөв тодорхойлж, шатахууныг зарцуулах.

**2. Илрүүлэлт:**

Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй 4,485.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**2.1. Эрсдэл:**

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

**3. Илрүүлэлт:**

Тус байгууллага нь харилцах данснаасаа 19,128.4 мянган төгрөгийг мөнгөн кассаар дамжуулан зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-д" төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянга) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

### 3.1. Эрсдэл:

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

### 3.2. Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулж зарлага гаргахдаа Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3 дахь хэсгийг хэрэгжүүлж ажиллах.

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 03/258 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ТАЙЛАН БИЧСЭН:

| | | |
|---|---|---|
| Бэлтгэсэн: Аудитор | Б.Азжаргал | Огноо |
| Анхан шатанд хянасан: Аудитын менежер | Б.Эрдэнэ | Огноо |
| Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор | Ц.Нармандах | Огноо |

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал "өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны маягт нөхөх заавар" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**2.1. Эрсдэл:**

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

**2.2. Өгсөн зөвлөмж:**

Бараа материалын бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй баримтаар гүйлгээ хийхгүй байх.

**3. Илрүүлэлт:**

Тус байгууллага нь харилцах данснаасаа 19,128.4 мянган төгрөгийг мөнгөн кассаар дамжуулан зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3-д" төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянга) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

**3.1. Эрсдэл:**

Хөрөнгө шамшигдах, хяналт алдагдах, хууль тогтоомж зөрчих.

**3.2. Өгсөн зөвлөмж:**

Бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулж зарлага гаргахдаа Сангийн сайдын 276 дугаар тушаалаар баталсан мөнгөн кассын журмын 6.3 дахь хэсгийг хэрэгжүүлж ажиллах.

**Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Төсвийн захирагчийн 2021.02.25-ны өдрийн 03/258 тоот албан бичгээр хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:20

2021.02.25

Аудитын нэр: Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Аудитын код: ОРА-2021/22/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газар

Мянган төгрөг

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй, жолоочийн тооцооны хуудас баталгаажаагүй, баримтаар шатахууныг зарцуулсан байна | 12,941.5 | Зөвлөмж | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| 2 | Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн. | 4,485.0 | Зөвлөмж | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| 3 | Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна. | 19,128.4 | Зөвлөмж | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| | 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн /тухайн онд үүссэн 46,863.9 мянган төгрөгийн өглөг, 25,339.6 мянган төгрөгийн авлага барагдаагүй/ зөвлөмж хэрэгжээгүй байна. | 72,053.5 | Албан шаардлага | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| | Жаргалант багийн зохион байгуулагч Ч.Батсуурьт үр дүнгийн урамшуулал илүү бодож олгосон байна. | 150.0 | Төлбөрийн акт | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| **ДҮН** | | **108,758.4** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|---|---|---|---|
| Огноо:20 2021.02.25 | Аудитын нэр: | Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: ОРА-2021/22/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газар | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Шатахууны анхан шатны болон зарцуулалтын баримт хангалтгүй, жолоочийн тооцооны хуудас баталгаажаагүй, баримтаар шатахууныг зарцуулсан байна | 12,941.5 | Зөвлөмж | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| 2 | Бараа материал худалдан авах орлого, зарлага, хүлээн авсан хүлээлгэн өгсөн баримтын бүрдэл хангалтгүй, гэрээ байгуулаагүй худалдан авалт хийсэн. | 4,485.0 | Зөвлөмж | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| 3 | Тус байгууллага нь харилцах данснаасаа мөнгөн кассаар дамжуулан бэлэн мөнгөөр ажил үйлчилгээ явуулсан байна. | 19,128.4 | Зөвлөмж | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| | 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн /тухайн онд үүссэн 46,863.9 мянган төгрөгийн өглөг, 25,339.6 мянган төгрөгийн авлага барагдаагүй/ зөвлөмж хэрэгжээгүй байна. | 72,053.5 | Албан шаардлага | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| | Жаргалант багийн зохион байгуулагч Ч.Батсуурьт үр дүнгийн урамшуулал илүү бодож олгосон байна. | 150.0 | Төлбөрийн акт | Дарга нягтлан бодогч | Т.Энхжаргал З.Сайнзаяа |
| | **ДҮН** | **108,758.4** | | | |

Бэлтгэсэн: Аудитор Б.Азжаргал Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах Огноо

**БАТЛАВ.**
ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР /Ц.НАРМАНДАХ/

*/гарын үсгийн тайлал/*

2021 оны 02 дугаар сарын 22 Орхон аймаг

**МЭДЭГДЭЛ**

Жаргалант сумын ЗДТГ-д

Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.” гэж заасны дагуу асуудлын бүртгэлд албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоохоор тусгагдсан алдаа зөрчилд албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох болсон тул Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн ___16:00____ цагт сонсох ажиллагааг биечлэн уулзах хэлбэрээр явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дараалаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Аудитор___________________________ /Б.Азжаргал/
*албан тушаал* *гарын үсэг*

Мэдэгдлийг хүлээн авсан:

Жаргалант сумын ЗДТГ-ын ня-бо З. Сайнзаяа /З.Сайнзаяа/
*албан тушаал* *гарын үсэг*

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо:__2021.02.22______

## СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ

№ 23

2021 оны 02-р сарын 22-ны өдөр — Орхон аймаг

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогчтой 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн _16:00_ цагт Нутгийн удирдлагын ордны 304 тоот албан өрөөнд биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр; Жаргалант сумын ЗДТГ-ын дарга — Т.Энхжаргал

Албан тушаал, нэр; Жаргалант сумын ЗДТГ-ын нягтдлан бодогч — З.Сайнзаяа

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх:

Татгалзаж байгаа шалтгаан:_______________

_______________гарын үсэг_______________

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна. Гарын үсэг_______________

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэл, мэдээллийг Жаргалант сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогчид танилцуулав.

Асуулт, хариулт: Асуудлын бүртгэлээр танилцуулсан акт тогтоох, албан шаардлага өгөх алдаа зөрчилтэй асуудалтай холбоотой санал тайлбар байна уу?

Асуудлуудтай танилцсан холбогдох санал, тайлбар байхгүй, цаашид анхаарч ажиллах болно.

64229,9 мянган төгрөгийн өр авлага баталгаажаагүй албан шаардлага хүргүүлж үр дүнгийн урамшуулал илүү олгосон 150,0 төгрөгийн актад хүлээн зөвшөөрч байна

___Сонсох ажиллагааг ______16:30___________цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл: Аудитор _______________/Б.Азжаргал/

Оролцогч: Жаргалант сумын ЗДТГ-ын дарга — Т.Энхжаргал — /Т.Энхжаргал/

Нягтлан бодогч — З.Сайнзаяа — /З.Сайнзаяа/

**ОРХОН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 59/59 ОРА-2021/22/СТА-ТШ3 Эрдэнэт хот

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жаргалант багийн зохион байгуулагчид үр дүнгийн урамшуулал болох 150.0 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэн заалт Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.4-д "төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журамд заасан нөхцөл, шалгуурыг баримтална" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон үр дүнгийн урамшуулал болох 150.0 мянган төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 тоот /Ор.Хүү торгуулийн орлого/ дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2021 оны 05 дугаар сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын дарга Т.Энхжаргал нягтлан бодогч З.Сайнзаяа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:..................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР..................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР..................................Б.АЗЖАРГАЛ

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр Дугаар 104/104 ОДА-2021/22/СТА-ТШЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн /тухайн онд үүссэн 46,713.9 мянган төгрөгийн өглөг, 25,339.6 мянган төгрөгийн авлага барагдаагүй/ зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн /тухайн онд үүссэн 46,713.9 мянган төгрөгийн өглөг, 25,339.6 мянган төгрөгийн авлага барагдаагүй/ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жаргалант сумын Засаг Даргын Тамгын Газрын дарга Т.Энхжаргал, нягтлан бодогч З.Сайнзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....................................Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР.....................................Б.ЭРДЭНЭ

АУДИТОР.....................................Б.АЗЖАРГАЛ